



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ХЭРЭГЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН СТАТИСТИКИЙН ЧАНАРЫН ТАЙЛАН

/Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа/

Улаанбаатар хот
2017 он

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|--------|--|
| ЭЗХТЗ | Эдийн засгийн харилцан туслах зөвлөл |
| ҮСГ | Үндэсний статистикийн газар |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| ДБ | Дэлхийн банк |
| НҮБХХ | Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр |
| ӨОЗС | Өрхийн орлого, зарлагын судалгаа |
| АТТС | Амьжиргааны түвшний түүвэр судалгаа |
| ӨОЗАТС | Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний судалгаа |
| ӨНЭЗС | Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа |
| ТАШН | Түүврийн анхан шатны нэгж |
| МХЗ | Мянганы хөгжлийн зорилт |

Агуулга

| | | |
|-----|---|----|
| 1 | Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны товч түүх | 4 |
| 2 | Нийтлэг үндэслэл | 6 |
| 3 | Судалгааны зорилго | 6 |
| 4 | Ойлголт, тодорхойлолт | 7 |
| 5 | Судалгааны талаарх ерөнхий мэдээлэл..... | 9 |
| 5.1 | Судлагдах нэгж..... | 9 |
| 5.2 | Судалгааны түүвэрлэлт | 10 |
| 5.3 | Мэдээлэл цуглуулах арга зүй | 11 |
| 5.4 | Ангилал, стандарт | 12 |
| 5.5 | Мэдээлэл боловсруулалт | 12 |
| 6 | Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын үзүүлэлт | 12 |
| 6.1 | Үнэн бодит, найдвартай байдал | 13 |
| 6.2 | Цаг хугацаандаа байх, шуурхай байх..... | 13 |
| 6.3 | Хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн байдал | 14 |
| 6.4 | Нийтэд хүртээмжтэй, ил тод байдал | 15 |
| 6.5 | Нийцтэй, харьцуулах боломжтой байдал..... | 16 |
| 7 | Нууцлалыг хангасан байдал..... | 17 |

1 Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны товч түүх

Эдийн засгийн харилцан туслах зөвлөл (ЭЗХТЗ)-ийн статистикийн салбарт хамтран ажиллах байнгын комиссын хуралдаанаас гишүүн орнуудад өрхийн орлого, зарлагын судалгаа явуулж байх зөвлөмж гаргасныг үндэслэн Сайд нарын зөвлөлийн 1964 оны 111 дүгээр тогтоолоор “Өрхийн төсвийн түүвэр судалгаа”-г 1964 онд бэлтгэлийг хангаж, 1965 оноос эхлэн тогтмол явуулахыг Статистикийн төв газарт /хуучин нэрээр/ даалгасан юм. Энэ нь Монгол Улсын Статистикийн албаны түүхэнд шинжлэх ухааны үндэстэй, цэгцтэй түүвэр судалгаа явуулах эхлэл нь байсан билээ. Өрхийн төсвийн судалгааг 1965 оноос ажилчин, албан хаагчийн 490 өрх, нэгдлийн гишүүний 510 өрхийг хамруулан явуулж эхэлсэн байна.

Монгол Улс 1991 оноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээр өрхийн төсвийн судалгааны зорилго өмнөхөөсөө нэлээд өөрчлөгдөж, олон улсын нийтлэг арга зүйгээр явуулах шаардлага гарсан билээ. Засгийн газрын 1991 оны 345 дугаар тогтоолоор “Өрхийн аж ахуйн судалгаа” нэртэйгээр 18 аймаг, 3 хотын нийт 1250 өрхөд 1992 оноос эхлэн зохион байгуулж явуулав.

Зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн он жилүүдэд Монгол Улсын нийгэм, эдийн засаг, ард түмний аж байдал, эрүүл мэнд, боловсрол, ажил эрхлэлтийн байдалд гарсан томоохон өөрчлөлтүүд нь хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлж, судалгаа шинжилгээ хийх, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарыг холбогдох судалгаа, материалаар хангахыг шаардаж байсан. Тиймээс ҮСГ-аас “Амьжиргааны түвшний түүвэр судалгаа”-г 1995 оноос хойш 3 удаа явуулсан байна. “Монгол Улсын хүн амын амьжиргааны түвшний үнэлгээ”-ний анхны түүвэр судалгааг Дэлхийн банкны техник санхүүгийн дэмжлэгтэйгээр 1995 онд явуулсан. Судалгаанд 1500 өрхийг хамруулан явуулсан бөгөөд судалгааны боловсруулалтыг SAS програмаар Дэлхийн банкны зөвлөхүүдийн хамт ҮСГ-ын мэргэжилтнүүд АНУ-ын Вашингтон хотноо хийж байсан байна.

1995-1998 онд хүн амын ядуурлын байдал хэрхэн өөрчлөгдөж, ямар дэвшил гарсныг дүгнэх зорилгоор хоёр дахь удаагийн судалгааг “Амьжиргааны түвшний түүвэр судалгаа” нэрээр 1998 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр 2000 өрхийг хамруулан явуулсан.

2002-2003 онд “Амьжиргааны түвшний түүвэр судалгаа”-ны түүвэрлэлтийн хэмжээ, түүний төлөөлөх чадварыг сайжруулах, боловсронгуй болгох зорилгоор ҮСГ нь НҮБХХ болон ДБ-ны санхүүгийн дэмжлэгтэйгээр “Өрхийн орлого, зарлагын судалгаа” төслийг хэрэгжүүлэв. “Өрхийн орлого, зарлагын судалгаа”-нд түүвэрлэлтийн олон шатат түүврийн аргыг хэрэглэж Улаанбаатар хот, 22 аймгийн нийт 11232 өрх хамрагдан улирлын турш 2808 өрхөөс судалгааг авч, өрхөө улирал бүр шинэчлэн сольж байв.

Судалгааг ядуурлыг тодорхойлох арга замыг сайжруулах, Монгол Улсын хүн амын аж байдал, ядуурлын талаар шинэ мэдээлэлтэй болох зорилгоор “Амьжиргааны түвшний түүвэр судалгаа” (АТТС)-г “Өрхийн орлого, зарлагын судалгаа” (ӨОЗС)-тай хослуулан “Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний судалгаа” (ӨОЗАТС) нэрээр олон улсын аргачлалын дагуу явуулсан байна.

“Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний судалгаа”-нд түүвэрлэлтийн олон шатат түүврийн аргыг хэрэглэсэн. Жилд 1248 түүврийн анхан шатны нэгжийн 11232 өрх ӨОЗС-нд хамрагдсан бөгөөд үүнээс 3308 өрх ӨОЗАТС-нд дахин сонгогдон судлагдсан.

ҮСГ-т хэрэгжүүлсэн төсөл 2003 оны 1 дүгээр сард дууссан бөгөөд энэ төслийг хэрэгжүүлэх “Харилцан ойлголцлын санамж бичиг”-т 2003 оноос ӨОЗС-г сайжруулсан аргачлалын дагуу Засгийн газрын зардлаар цаашид үргэлжлүүлэн явуулж байхаар тусгагдсан байна.

Дэлхий даяар ядууралтай холбоотой асуудлууд хурцаар тавигдах болж, ядуурлыг бууруулах, ядуурлаас гарах чиглэлээр улс орнууд, олон улсын байгууллагууд хамтран ажиллаж, Монгол Улс дэлхий нийтийн энэхүү уриалгад нэгдэн орсноор ядуурлын эсрэг, ядуурлыг бууруулах үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд ядуурлын тадаарх бодитой тоо, мэдээллийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалаар тооцож, мэдээллийг шинэчлэх зайлшгүй шаардлага гарч байв. Үүний дагуу Үндэсний статистикийн хорооноос амьжиргааны түвшин, ядуурлын үзүүлэлтээр баяжуулсан өрхийн судалгааг ДБ-ны зөвлөмж, арга зүйгээр “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа” (ӨНЭЗС) нэрийн дор орон даяар 2007 оны 7 дугаар сарын 1-нээс зохион байгуулан явуулж байна.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа нь өрхөд суурилсан нийгэм, эдийн засгийн мэдээллийг түшиглэн Монгол Улсын хүн амын амьжиргааны байдал, ядуурал, өрхийн орлого, зарлага, хэрэглээ болон бусад үзүүлэлтийг тодорхойлох үндсэн зорилготой бөгөөд мэдээллийн хэрэгцээ, ашиглалт, давтамж зэргээс шалтгаалан 2013 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн сондгой тоотой жилүүдэд өрхийн орлого, зарлага, хэрэглээний үзүүлэлтүүдийг шинэчлэх зорилтыг хангахуйц байдлаар хураангуй хэлбэрээр, 2012 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн тэгш тоотой жилүүдэд хүн амын аж байдал, ядуурлын үзүүлэлтүүдийг тооцох зорилгоор хураангуй судалгааны асуулгыг баяжуулан дэлгэрэнгүй хэлбэрээр явуулж байна.

2 Нийтлэг үндэслэл

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 1.2-ын “г, д, е”-д заасны дагуу өрх, хүн амын орлого, зарлага, хэрэглээ; хүн амын хүнсний хангамж, илчлэг; хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын албан ёсны статистик мэдээллийг гаргах, 7 дугаар зүйлийн 1-д зааснаар “Өрхийн нийгэм, эдийн засгийн түүвэр судалгаа”-г улирал тутам явуулах; мөн “Өрх, хүн амын орлого, зарлагын мэдээллийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 235 дугаар тогтоолын дагуу Үндэсний статистикийн хороо (ҮСХ) нь 2007 оны 7 дугаар сарын 1-нээс “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-г зохион байгуулан явуулж байна.

3 Судалгааны зорилго

Хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын дүн шинжилгээг хийхэд ашиглах: ӨНЭЗС-г явуулсанаар хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын дүр төрхийг тодорхойлох шаардлагатай иж бүрэн, нэгдсэн мэдээллийн үндсэн бааз бий болно. Хэрэглээ болон зардлын талаар хангалттай мэдээлэл цугларсанаар судалгаанд оролцогч өрхийн амьжиргааны түвшинд үндэслэн нэг хүнд ногдох хэрэглээний түвшинг тооцож гаргах боломж бүрдэнэ. Өрхүүдийг ядуу ба ядуу бус гэж ангилахын тулд судалгаанд оролцогч өрх бүрийн хэрэглээний түвшин нь эцсийн

шатанд ядуурлын шугамтай харьцуулагдах бөгөөд ядуурлын шугамыг энэхүү судалгааны мэдээллийг үндэслэн мөн тодорхойлж гаргана.

Бодлогын дүн шинжилгээ хийхэд ашиглах: Энэхүү судалгаа нь дараах сэдвүүдийг хамарсан бодлогын асуудлуудад хэрэглэгдэнэ.

- Өрхийн хэрэглээ, зардлын хэв маяг;
- Орлогын эх үүсвэр болон ажил эрхлэлт;
- Хөрөнгө эзэмшлийн байдал;
- Өрхийн аж ахуй эрхлэлт;
- Хүнс, тэжээлийн хэрэглээ;
- Эрүүл мэнд;
- Боловсрол;

Ийм төрлийн нэгдсэн судалгааг явуулахад эдгээр бодлогын асуудлуудыг салангид байдлаар эсвэл нийлмэл байдлаар нь тодруулж болдог. Жишээ нь боловсрол эзэмшсэн байдал нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэв маягт хэрхэн нөлөөлж байна вэ? гэдгийг тодруулж болно.

Өрхийн эцсийн хэрэглээний зардлыг үнэлэх: Судалгаанд тусгасан өрхийн зардлын талаарх мэдээллийг ашиглан өрхийн хэрэглээний зардлын эцсийн үнэлгээг шууд тооцон гаргах боломжтой.

4 Ойлголт, тодорхойлолт

Өрх: Ганц бие болон нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг хэлнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо ураг төрлийн холбоотой, хамаатан садан, зарим гишүүд нь огт хамааралгүй, эсвэл эдгээрийн аль алианаас бүрдсэн байж болно. Гэр бүл ба айл өрх нь хоорондоо ялгаатай ойлголт. Гэр бүл гэдэг нь нийгмийн харилцаа, цусан төрлийн холбоо, гэрлэлтээр хоорондоо холбогдсон хүмүүст хамаарна. Харин өрх гэдэг нь эдийн засгийн хувьд бие даасан нэгжийн тухай ойлголт юм. Хэдийгээр гэр бүл, айл өрх гэдэг ихэвчлэн адилхан мэт ойлголт боловч тэр болгон нэг утгаар энэ ойлголтыг хэрэглэж болдоггүй.

Өрхийн мөнгөн орлого: Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого болон бусад орлогоос бүрдэнэ.

Өрхийн мөнгөн зарлага: Өрхийн хүнсний бүтээгдэхүүн, хүнсний бус бараа, үйлчилгээний болон бусдад өгсөн бэлэг, тусламж, бусад зарлага багтана.

Өрхийн хүнсний зүйлийн хэрэглээ: Өрхийн худалдан авсан болон өөрийн аж ахуйгаас бэлтгэсэн мөн бусад эх үүсвэрээс авсан хүнсний бүтээгдэхүүнээс тухайн сард хүнсэндээ хэрэглэсэн бараа, бүтээгдэхүүний биет хэмжээ нь өрхийн хүнсний зүйлийн хэрэглээг тодорхойлно.

Өрхийн хүнсний зарлага: Энэ нь өрхийн зөвхөн хүнсний хэрэглээнд зарцуулсан зүйлийн зардлын хэмжээ болно. Тэгэхээр энэхүү хэрэглээнд өрхийн хөдөө аж ахуйн болон хөдөө аж ахуйн бус бизнес, үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, бусад төлбөрт үйл ажиллагаатай холбогдсон зардал үл хамаарна.

Өрхийн хүнсний мөнгөн зарлага: Өрхийн тухайн сард хүнсний хэрэглээндээ зориулж худалдан авсан хүнсний бараа, бүтээгдэхүүний мөнгөн зарлага юм.

Бусдаас үнэгүй авсан (бэлэг, тусламж, хандив буюу үнэгүй авч хэрэглэсэн) зүйлс: Судалгааны хугацаанд бусдаас үнэгүй буюу бэлгэнд авч хэрэглэсэн хүнсний болон хүнсний бус зүйлүүд хамаарна. Бусдаас (бусад өрх, сайн дурын тусламжийн байгууллага, засгийн газар, гадаадын иргэдээс) бэлэг, тусламж, хандив болгон өгсөн шинэ болон хуучин хүнсний бус зүйлүүд мөн орно.

Ядуурал: Ядуурал нь хувь хүний аж байдлын доройтол, хомсдолтой байдлаар илрэх бөгөөд эрүүл мэнд, боловсрол, оюуны болон биеийн чадавхи доройтох, хоол тэжээлийн хомсдол, бараа үйлчилгээний дутагдалд орох, дэд бүтцийн үйлчилгээнүүдийн хүртээмж хязгаарлагдмал байх, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх чадвар хангалтгүй байх зэргээр илэрдэг.

Ядуурлын шугам: Ядуурлын шугам нь тодорхой өгөгдсөн цаг хугацаа, оршин байгаа орчинд хувь хүний амьжиргааны түвшинг мөнгөн дүнгээр илэрхийлсэн утга болно. Ядуурлын шугам нь ядуу хүнийг ядуу бус хүнээс ялгах гол шалгуур үзүүлэлт юм. Ядуурлын шугам нь хүний эрүүл, идэвхитэй амьдралыг хангахуйц илчлэгтэй хоол, тэжээлийн хэрэгцээг тусгасан хэрэглээний хамгийн бага зардал болно.

Ядуурлын хамралтын хүрээ: Энэ хэмжүүр нь нийт хүн амын тоонд ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын эзлэх хувь хэмжээг илэрхийлнэ. Энэ хэмжүүр нь “хувиар” тодорхойлогдоно.

Ядуурлын гүнзгийрэлт: Энэ хэмжүүр нь хүн амын хэрэглээ ядуурлын шугамаас хэр зэрэг доогуур байгааг тодорхойлно. Энд хэрэглээний дутагдал, хомсдол их байх тутам гүнзгийрэлт өндөр байна. Энэ хэмжүүр нь “хувиар” тодорхойлогдоно.

Ядуурлын мэдрэмж: Ядуучуудын дундах хэрэглээний тархалтын мэдрэмжийг илэрхийлнэ.

Жини коэффициент: Энэ хэмжигдэхүүн нь хүн амын хэрэглээний тэнцүү бус хуваарилалтыг илэрхийлсэн коэффициент юм. Жини коэффициент нь (0-1)-ийн хооронд утга авах бөгөөд нэг гэсэн утганд ойртох тусам хэрэглээний тэгш бус байдал өндөр, харин 0-тэй тэнцүү бол орлогын хуваарилалтанд ялгаа байхгүй байгааг илэрхийлнэ.

5 Судалгааны талаарх ерөнхий мэдээлэл

5.1 Судлагдах нэгж

Судалгаа явагдах хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр амьдарч байгаа өрх болон тухайн өрхийн хүн ам нь судалгааны судлагдах нэгж байна. Дараах хүн амыг судалгаанд хамруулахгүй. Үүнд:

- Монгол Улсад ажиллаж амьдарч буй гадаадын иргэд (элчин сайдын яамд, төлөөлөгчдийн газар, олон улсын байгууллагын ажилтнууд, гэрээгээр ажиллагчид, жуулчид)
- Хорих газарт хоригдогсод
- Халамжийн төвүүд, асрах газарт амьдрагсад
- Хугацаат цэргийн албан хаагчид
- Дотуур байранд амьдардаг оюутнууд байна.

5.2 Судалгааны түүвэрлэлт

Судалгааны түүврийн зохиомж нь дэлгэрэнгүй болон хураангуй судалгааны хувьд ялгаатай байна.

Хураангуй хэлбэрийн ӨНЭЗС-ны хувьд:

Судалгааны түүврийн зохиомжид Хот (Улаанбаатар, аймгийн төв), хөдөө (сумын төв, хөдөө нутаг) гэсэн бүлгийг ашигласан. Түүврийн анхан шатны нэгж (ТАШН) нь Улаанбаатарт хэсэг, аймгийн төв болон хөдөөд баг бөгөөд нийт 1248 ТАШН-ийг бүтэн жилийн туршид хамруулна. Түүврийн хуваарилалтыг хийхдээ аймгуудын үр дүнг хооронд нь харьцуулагдахуйц байлгахын тулд тэгш хуваарилалтын аргаар хийж, ТАШН-ийг 2 шатат энгийн санамсаргүй аргаар хийсэн.

Улаанбаатар хотод 360 ТАШН, аймаг тус бүрээс аймгийн төвүүдэд 12 ТАШН (Дархан-Уул аймагт 24 ТАШН, Орхон аймагт 24 ТАШН, Говьсүмбэрт 0 ТАШН), харин Хөдөөд хүн амын тоонд пропорциональ магадлалаар 12-60 ТАШН түүвэрлэн авсан ба Улаанбаатар хот болон аймгийн төвийн ТАШН тус бүрээс 10 өрхийг, хөдөөгийн ТАШН тус бүрээс 8 өрхийг сонгосон.

Нийт 11232 өрхөөс 3600-г Улаанбаатар хотод, 2640-г аймгийн төвүүдэд, 4992-г сумын төв болон хөдөө нутагт хуваарилсан бөгөөд улсын хэмжээнд төлөөлөх чадвартай статистикийн тоо мэдээлэл цуглуулахын тулд түүвэрлэлтийн жинг ашигласан. Уг жинг түүврийн стратегийг ашиглан сонголтын магадлалтай нь урвуугаар авч өрх бүрд оноосон.

Дэлгэрэнгүй хэлбэрийн ӨНЭЗС-ны хувьд:

Судалгааны түүврийн зохиомжид Хот (Улаанбаатар, аймгийн төв), хөдөө (сумын төв, хөдөө нутаг) гэсэн бүлгийг ашигласан. Түүврийн анхан шатны нэгж (ТАШН) нь Улаанбаатарт хэсэг, аймгийн төв болон хөдөөд баг бөгөөд нийт 1836 ТАШН-ийг бүтэн жилийн туршид хамруулна. Түүврийн хуваарилалтыг хийхдээ аймгуудын үр дүнг хооронд нь харьцуулагдахуйц байлгахын тулд тэгш хуваарилалтын аргаар хийж, ТАШН-ийг 2 шатат энгийн санамсаргүй аргаар сонгосон.

Улаанбаатар хотод 360 ТАШН, аймгийн төв бүрээс 24 ТАШН (Дархан-Уул аймагт 36 ТАШН, Орхон аймагт 60 ТАШН, Говьсүмбэрт 12 ТАШН), харин хөдөөд 48

ТАШН (Өвөрхангай 60, Хөвсгөл 60, Дархан-Уул аймагт 24, Орхон аймагт 0, Говьсүмбэрт 24 ТАШН) түүвэрлэн авсан ба Улаанбаатар хот болон аймгийн төвийн ТАШН тус бүрээс 10 өрхийг, хөдөөгийн ТАШН тус бүрээс 8 өрхийг сонгосон.

Нийт 16488 өрхөөс 3600-г Улаанбаатар хотод, 5400-г аймгийн төвүүдэд, 7488-г сумын төв болон хөдөө нутагт хуваарилсан бөгөөд улсын хэмжээнд төлөөлөх чадвартай статистикийн тоо мэдээлэл цуглуулахын тулд түүвэрлэлтийн жинг ашигласан. Уг жинг түүврийн стратегийг ашиглан сонголтын магадлалтай нь урвуугаар авч өрх бүрд оноосон.

5.3 Мэдээлэл цуглуулах арга зүй

Мэдээллийг цуглуулахдаа өрхөд өдрийн тэмдэглэл хөтлүүлэх болон нэг удаагийн асуулгаар сануулж авах аргыг хослуулан ашиглана. Хотын өрх (Улаанбаатар, аймгийн төвийн өрх)-д нэг удаагийн асуулга болон өдрийн тэмдэглэл хөтлүүлж авах аргыг хамт хэрэглэнэ. Хөдөөгийн өрх (сумын төв, хөдөөгийн өрх)-д нэг удаагийн асуулгаар сануулж авах аргыг хэрэглэнэ.

Асуулгын маягт:

ӨНЭЗС-ны асуулга нь 3 үндсэн маягтаас (ӨНЭЗС-1, ӨНЭЗС-2, ӨНЭЗС-3) бүрдэнэ. Үүнд:

- Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаатай холбогдолтой үзүүлэлтүүдийн асуулга (ӨНЭЗС-1).
Судлаач өрхөд сар бүр очиж өрхөөс асууж нөхнө. Хотын өрхүүдээс судлаач мэдээлэл цуглуулах графикайн дагуу 4-6 удаагийн очилтоор мэдээллийг цуглуулна. Мэдээлэл цуглуулах графикайг судлаачид зориулсан зааварт тусгасан байна.
- Өрхийн хүнсний хэрэглээ, зардлыг бүртгэх асуулга (ӨНЭЗС-2).
Судалгаанд ажиллах судлаач өрхийн хүнсний зүйлийн хэрэглээ, зардлыг ӨНЭЗС-2 (хот, суурин газарт ӨНЭЗС-2а, хөдөөд ӨНЭЗС-2б) маягтаар бүртгэнэ. ӨНЭЗС-2а маягтыг хөтлөхдөө өрхийн өдрийн тэмдэглэл (ӨНЭЗС-3) дээр үндэслэн 10 хоног тутам нөхнө. ӨНЭЗС-2б маягтыг судлаач өрхөөс сард нэг удаа асууж нөхнө.
- Өрхөд хөтлүүлэх өдрийн тэмдэглэл (ӨНЭЗС-3).

Өрхийн хэрэглэсэн хүнсний зүйлийн хэрэглээг өдөр бүр тэмдэглэх өдрийн тэмдэглэлийг хот, суурин газрын сонгогдсон өрх бүр дээр өрхийн гишүүдээр өөрсдөөр нь 1 сарын турш хөтлүүлнэ.

5.4 Ангилал, стандарт

- Монгол Улсын Засаг захиргааны ангилал, код
- Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (ISCO-08)
- Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ISIC-4.0)
- Хувийн зориулалттай хэрэглээний бараа, үйлчилгээний ангилал (COICOP)

5.5 Мэдээлэл боловсруулалт

Судалгааны асуулга боловсруулах, мэдээллийг шивэх програм зохиох бэлтгэх, шивэгдсэн мэдээллийг хүлээн авах, хянах, засварлах, боловсруулах, нэгдсэн үр дүнг гарган авах ажлуудыг ҮСХ-нд, харин өрхөөс ярилцлага авах, цуглуулсан мэдээллийг зааврын дагуу шалгаж, кодлон таблетанд шивж оруулах, ҮСХ-нд дамжуулах ажлуудыг нийслэл, аймгийн газар, хэлтсийн судалгааны баг хариуцан гүйцэтгэнэ.

ӨНЭЗС-ны мэдээллийг таблетанд шивж оруулахдаа мэдээлэл боловсруулалтын CPro програмыг ашигладаг бөгөөд мэдээллийн чанарыг баталгаажуулахын тулд мэдээллийн иж бүрдэл, бодит байдалд шалгалт хийж алдаатай мэдээллийг аймгуудаас эргэж тодруулан, холбогдох засварыг үндсэн баазад тусган мэдээллийн санг эцэслэнэ. Мэдээллийн сангаас үр дүнг нэгтгэн холбогдох хүснэгтүүдийг STATA програм ашиглан боловсруулалтаа хийнэ.

6 Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын үзүүлэлт

Статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын олон талт ойлголттой холбоотойгоор бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар нь хэрэглэгчдийн үнэлэх үнэлэмж, хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлага болон мэдээллийн чанар, ач холбогдлоор тодорхойлогдож байна. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны

чанарын үзүүлэлтийг ҮСХ-ны чанарын бодлогын баримт бичигт тусгасан дараах шалгуур үзүүлэлтүүдээр тодорхойлов. Үүнд:

6.1 Үнэн бодит, найдвартай байдал

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны тоон мэдээллийг үнэн бодитой, чанартай цуглуулахын тулд дараах зарчмыг баримтална.

- ҮСХ-ны ӨНЭЗС-ны баг болон орон нутагт ажиллах ажилтнууд (ахлагч, хянагч, судлаач) нар ҮСХ-ны даргын 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/193 дугаар тушаалаар батлагдсан “ҮСХ-ны судалгааны багийн ажиллах журам”, “Судалгааны мэдээлэл цуглуулах багийн ажиллах журам”-ыг мөрдлөг болгон ажиллана.
- Судалгаанд ажиллах ажилтнууд (ахлагч, хянагч, судлаач) нь батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалтанд хамрагдсан байна.
- Судалгаанд ажиллах ажилтнууд (ахлагч, хянагч, судлаач) нь нарийн заасан зааврын дагуу ажлын чиг үүргийг баримталж ажиллана.
- Судалгаанд ажиллахаар сонгогдсон ажилтнуудын ажлын явцад хяналт тавих ажлыг ҮСХ болон орон нутгийн статистикийн газар/хэлтсийн дарга нар хариуцаж зохион байгуулна.

6.2 Цаг хугацаандаа байх, шуурхай байх

- Хүн, амын өрхийн мэдээллийн сангаас судалгаанд хамрагдах өрхийг ҮСХ-ны судалгааны үндсэн баг түүвэрлэж нийслэл/аймгийн статистикийн газар/хэлтэс рүү хүргүүлнэ.
- Судлаач түүврийн дагуу сонгогдсон өрхүүдээс тухайн сард мэдээллээ цуглуулж, мэдээллийг ҮСХ-ны судлаачийн мэдээлэл байрших серверт дараа сарын 2/3-ны дотор дамжуулна.
- Нийслэл/аймгийн статистикийн газар/хэлтэс (ҮСХ)-ны судлаачийн мэдээлэл байрших серверээс мэдээллийг авч шалган ахлагчийн мэдээлэл байрших серверт сар бүрийн 5/8-ны дотор дамжуулна.
- Судалгааны мэдээллийн боловсруулалт, үр дүнгийн үзүүлэлтүүдийг тооцон гаргах ажлыг ҮСХ-ны судалгааны үндсэн баг хийж гүйцэтгэнэ.

- Судалгааны үндсэн баг судалгааны үр дүнг улирал, жилээр ҮСХ-ноос тогтоосон мэдээ, тайлан тархаах графикт хугацааны дагуу хэвлэмэл болон электрон хэлбэрээр хэрэглэгчдэд тархааж байна.

6.3 Хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн байдал

Үндэсний статистикийн хороо нь өрхөд суурилсан нийгэм, эдийн засгийн мэдээллийг түшиглэн Монгол Улсын хүн амын амьжиргааны байдал, ядуурал, өрхийн орлого, зарлага, хэрэглээ болон бусад үзүүлэлтүүдийг олон улсын жишиг аргачлалд нийцүүлэн, үндэсний онцлогийг тусгасан нэгдсэн аргачлалаар тодорхойлж, бодлого боловсруулагч, судлаач, шинжээч нарыг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-г улсын хэмжээнд зохион байгуулан явуулж, сар бүр мэдээллээ цуглуулж, тооцоолол хийн үр дүнг улирал, жилээр тархаан ажиллаж байна.

Судлагдах сэдвийг хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслэн, нийгэм, эдийн засгийн үзэгдлүүдийн өөрчлөлтийг бодитой мэдэрч, цаг тухайд нь тусгадаг байх үүднээс ач холбогдол, судлагдах давтамжийн хувьд ангилж 2 жил тутам дэлгэрэнгүй хэлбэрээр, жил тутам хураангуй хэлбэрээр ӨНЭЗС-г зохион байгуулан явуулж байна. Ингэснээрээ ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг 2 жил тутамд тодорхойлох, ДНБ-ийг хэрэглээний аргаар тооцоход шаардлагатай мэдээлэл, МХЗ-ын үзүүлэлтүүд, бусад тооцоонуудыг гаргахын зэрэгцээ, зарим сэдвийг төрөөс явуулж буй бодлоготой, зарим сэдвийг өөрчлөлтийн хандлагатай нь уялдуулан судлаж байна.

Жил тутам улирлаар явагдах ӨНЭЗС-гаар дараах бүлэг мэдээллийг цуглуулна.

- Өрхийн ам бүлийн байдал
- Ажил эрхлэлт
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хэрэглээ
- Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ
- Бусад орлого
- Хадгаламж, зээл
- Орон сууц, эрчим хүч
- Хүнсний бус зардал, хэрэглээ

- Хүнсний зардал, хэрэглээ
- Хоол, тэжээлийн хөтөлбөрийн үнэлгээ

Хоёр жил тутамд дэлгэрэнгүй хэлбэрээр явагдах ӨНЭЗС-ны хувьд жил тутам явагдах хураангуй судалгааны судлах сэдвүүд дээр дараах бүлэг мэдээллийг нэмж цуглуулна.

- Боловсрол
- Эрүүл мэнд
- Бусдаас авсан бэлэг, тусламж, хандив
- Удаан эдэлгээтэй бараа, эд хогшил

6.4 Нийтэд хүртээмжтэй, ил тод байдал

Үндэсний статистикийн хорооны хувьд бүх хэрэглэгчдийг статистикийн мэдээллээр адил тэгш хангах зарчим баримталдаг бөгөөд хуулийн хүрээнд бүх мэдээлэл хэрэглэгчдэд нээлттэй, ил тод байдаг. Нийтэд хүртээмжтэй, ил тод байдлыг хангахдаа мэдээллийн нууцлалыг чандлан хадгалдаг.

Хэрэглэгчдэд ӨНЭЗС-ны мэдээллийг хүснэгтэн, инфо график, танилцуулга, тайлан хэлбэрээр тархахаас гадна статистик мэдээллийн нэгдсэн сан болох www.1212.mn сайтын Дэд мэдээллийн сан/Тооллого судалгааны каталогит ӨНЭЗС-ны нууцлалыг хангасан анхдагч мэдээллийн бааз /дата/-ыг байрлуулан нийтэд үнэ төлбөргүйгээр хүргэж байна. Уг каталоги нь ҮСХ-ны хэмжээнд зохион байгуулагдсан тооллого, судалгааны мэдээллийг агуулах бөгөөд судалгааны арга, аргачлал, агуулга, хэрхэн зохион байгуулагдсан тухай мэдээлэл, тэдгээрийн анхдагч мэдээллийн файл, холбогдох материалуудыг харах, татаж авч ашиглах боломжийг олгоно.

Нөгөө талаас хэрэглэгчдэд хүртээмжтэй, орон зай цаг хугацаанаас хамаарахгүйгээр хүссэн мэдээллээ авах боломжийг бүрдүүлсэн www.1212.mn вэб сайтын үзүүлэлтүүдийг iPhone, iPad, Android төхөөрөмж ашиглан үзэх боломжтой ezStat аппликейшн, iPhone, iPad, Android төхөөрөмжүүдэд зориулсан статистикийн хэвлэмэл бүтээгдэхүүнийг унших боломжтой Monstat аппликейшнийг ашиглан тархааж байна.

6.5 Нийцтэй, харьцуулах боломжтой байдал

Үндэсний статистикийн хорооноос гаргаж байгаа үзүүлэлтүүд нь цаг хугацаа, орон зай, арга зүйн хувьд харьцуулагдахуйц байдаг. Цаг хугацааны хувьд харьцуулагдахуйц байдал нь динамик мэдээллийн уртаар тооцогдохоос гадна хэрэглэгч харьцуулалт хийхдээ мэдээллийн давтамж (сар, улирал, жил)-ийг харгалзан ижил цаг хугацааг харьцуулах, орон зайн хувьд үндэсний, бүс нутгийн, аймаг орон нутгийн гэх зэргээр засаг захиргааны нэгжээр харьцуулагдахуйц байх шаардлагатай байдаг.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны хувьд мэдээллийн хэрэгцээ, ашиглалт, давтамж зэргээс шалтгаалан тэгш тоотой жилүүдэд буюу 2 жил тутам дэлгэрэнгүй хэлбэрээр судалгааны асуулгыг амьжиргааг тодорхойлох үзүүлэлтүүдээр баяжуулан хүн амын аж байдал, ядуурлын үзүүлэлтүүдийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалаар тооцдог бөгөөд жил тутам хураангуй хэлбэрээр өрхийн орлого, зарлага, хэрэглээний үзүүлэлтүүдийг шинэчлэх зорилтыг хангахуйц байдлаар явуулж тоо мэдээллийг баяжуулж байна. Үүнд:

- ✓ Нэг өрхийн сарын дундаж орлого, зарлага
 - улсын дундаж, хот, хөдөө, суурьшлаар
 - улирал, жилээр
- ✓ Нэг өрхийн сарын дундаж орлого, зарлагын бүтэц
 - улсын дундаж, хот, хөдөө, суурьшлаар
 - улирал, жилээр
- ✓ Өрхийн бүлэглэлт мөнгөн орлого, зарлагаар, дүнд эзлэх хувиар
 - улсын дундаж, хот, хөдөө, суурьшлаар
 - улирал, жилээр
- ✓ Нэг хүнд сард ногдох хүнсний зарим бүтээгдэхүүний улсын дундаж хэрэглээ, жишсэн хүнээр
 - улсын дундаж, хот, хөдөөгөөр
 - жилээр
- ✓ Нэг хүний хоногт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний илчлэг, найрлага
 - улсын дундаж, хот, хөдөөгөөр
 - жилээр

- ✓ Ядуурлын үндсэн үзүүлэлт
 - улсын дундаж, хот, хөдөө, бүс, суурьшлаар, нийслэл, аймгаар
 - хоёр жил тутам
- ✓ Нэг хүнд ногдох сарын хэрэглээ, хэрэглээний үндсэн бүлгээр
 - улсын дундаж, хот, хөдөөгөөр
 - хоёр жил тутам
- ✓ Нэг хүнд ногдох сарын хэрэглээ, өрхийн тооны тэнцүү 10 бүлгээр
 - улсын дундаж, хот, хөдөөгөөр
 - хоёр жил тутам
- ✓ Хүн амын хэрэглээний бүтэц, өрхийн тооны тэнцүү 5 бүлгээр, дүнд эзлэх хувиар
 - улсын дундаж, хот, хөдөөгөөр
 - хоёр жил тутам

ӨНЭЗС-ны мэдээлэл нь цаг хугацааны болон орон зайн хувьд харьцуулагдахуйц байдал хангагдаж, өмнөх оныхтой харьцуулсан үр дүнг нэгтгэн судалгааны үндсэн үр дүнгийн тайлан (“Ядуурлын дүр төрх” - 2007/2008, 2010, 2012, 2014, 2016, “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2010-2015 оны танилцуулга”) хэвлэн тархаасан.

7 Нууцлалыг хангасан байдал

Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн 22 дугаар зүйлийн 3 дугаар заалтыг үндэслэн мэдээллийн нууцыг хадгална. Судалгаанд ажиллаж байгаа бүх шатны ажилтнууд өрхийн мэдээллийг бусдад задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 22 дугаар зүйлийн 7-д “Тооллого, түүвэр судалгаанд хамрагдсан хувь хүн, хуулийн этгээдийн анхдагч мэдээлэлд боловсруулалт хийж, хэрэглэгчдэд ашиглуулж болно. Анхдагч мэдээлэлд боловсруулалт хийж, хэрэглэгчдэд ашиглуулахтай холбогдсон журмыг нууцын тухай хууль тогтоомжид нийцүүлэн Үндэсний статистикийн хорооны дарга батална” гэсэн заалттай.

Мөн “Үндэсний статистикийн хорооны нууцын тухай журам” болон “Тооллого, түүвэр судалгааны анхдагч мэдээллийг хэрэглэгчдэд ашиглуулах журам” зэргийг үндэслэн, гэрээ хийж нууцлалыг хангасан анхдагч мэдээллээр бүх хэрэглэгчдэд ашиглах эрхийг олгодог.

Уг чанарын тайланд дурьдагдсаны дагуу “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-г ҮСХ-ноос жил бүр уламжлал болгон чанарын өндөр түвшинд зохион байгуулан явуулж, үр дүнг цаг хугацаандаа, үнэн зөв, шуурхай, ил тодоор хэрэглэгчдэд хүргэж байгаа болно.

Энэхүү чанарын тайлантай холбогдолтой асууж, тодруулах зүйлээ hse@nso.mn цахим хаягаар болон 51-262325 утсаар лавлана уу.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО
ХҮН, АМ НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР